

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 05 дугаар сарын 01

Эрүүл мэндийн газар

Бүтэц	Дугаар	Агуулга	Шалгуур үзүүлэлт	хэмжих нэгж	хэрэгжих хугацаа	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
							Он	түвшин			
1. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО											
Зорилго	1	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ.	Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөцийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 48,8 Хандив 12.7	2023	85	90	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 дүгээр тушаалаар батлагдсан "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн байгууллагын нөөц"-д байвал зохих 46 нэр төрлийн эм, 39 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 11 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 6 нэр төрлийн тоног төхөөрөмж, 4 нэр төрлийн оношлуур, 7 нэр төрлийн ариутгал халдваргүйтгэлийн бодисыг бүрдүүлж гамшгийн үеийн бэлэн байдлыг хангаж байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 3.4 сая төгрөгийн хоол тэжээл багц, Велл бии ХХК -аас 9.3 сая төгрөгийн иргэдийн дархлаажуулалт дэмжих эм бэлдмэлийн тус тус олголоо. Гамшгийн үеийн нөөцийн хангалт 90,2 хувьтай байна.	100
			Теле хичээл тогтмол судлан үзэж буй сурагчдын эзлэх хувь	хувь	2021-2024		2023	85	95		
Зорилт	1.1	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ.	Нэмэгдсэн санхүүжилтийн хэмжээ	Сая.төг	2021-2024	ДЭМБ 74.4 УТХО 321.6 Хандив 527.1	2023	485.0	535.0	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зудын нөхцөл байдалтай холбогдуулан Өлзийт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдад нийт 13,0 сая төгрөгийн бүлээцүүлэх хөнжил, 7,8 сая төгрөгийн хэм хяналтын термостат, аймгийн хэмжээний нийт 68 багийн эмч нарын ажиллах нөхцлийг сайжруулах хүрээнд 53.6 сая төгрөгийн багийн эмчийн үзлэгийн цүнхийг тус тус хандивлаж нөөцийн бэлэн байдлыг хангалаа. Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 923.1 сая төгрөгийн санхүүжилт авсан.	100
Арга хэмжээ	1.1.1	Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх.	Эрсдэлт бүлгийн хүн амын хамрагдалтын хувь	хувь	2021-2024	-	2023	83.9	90	2024 оны 10 дугаар сард хийгдэнэ.	ХБ
	1.1.2	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах.	Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 3.5	2023	85	90	18 дугаар 7 хоногт аймгийн хэмжээнд эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн амбулаториор үйлчлүүлэгсдийн дунд томуу томуу төст өвчин 10,000 хүн амд 40,9, түргэн тусламжийн дуудлагад томуу, томуу төст өвчний тохиолдол 4.3 байгаа нь томуу, томуу төст өвчний тархалтын түвшин "АЙМГИЙН ХЭМЖЭЭНИЙ ИДЭВХЖИЛ"-ийн түвшинд байна. Эдгээр бүртгэгдсэн томуугийн өвчлөлд А(Н3N2) вирус, аденовирусын идэвхжил нэмэгдсэн хандлагатай байна. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 тушаалаар батлагдсан 18 нэр төрлийн тоног төхөөрөмжийн хангалт 90,7 хувьтай байна.	100
			Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийн хангалтын хувь	хувь	2021-2024		2023	58	60	Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харъяа Сувилахуйн сургуультай хамтран "Өмийн зохистой хэрэглээ" сэдэвт сургалтыг 112 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулж, эм эмнэлгийн хэрэгсэлийн бэлэн байдалд үнэлгээ хийлээ. Гамшгийн үеийн нийт 107 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийн байхаас 93 төрөл байна. Хангалт 86,9 хувьтай байна.	
1.1.4	Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах.	Сурган дадлагажуулсан бүрэлдэхүүний тоо	тоо	2021-2024	УТХО 0.4	2023	55	55	Гамшгаас хамгаалах хуулийн 32 дугаар зүйлийн 32,1 дэх заалт , Монгол улсын засгийн газрын 2011 оны 339, 340 тогтоолын дагуу газар хөдөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах зарлан мэдээлэх дохиоллоор ажиллах дадлага сургуулилтад Эрүүл мэндийн албаны штаб, мэргэжлийн ангиуд болон эмнэлгийн ажилчид нийт 93 хүн хамрагдсан.	100	
		Сурган дадлагажуулсан мэргэжлийн ангийн тоо бүрэлдэхүүний тоо	тоо	2021-2024		2023	2	2	"Гамшгийн үеийн сэтгэц-нийгмийн дэмжлэг үзүүлэх" говийн бүсийн бүсчилсэн танхимын сургалтад 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Осголт, хөдөлтийн үед авах арга хэмжээ, Угаарын хийн хордлогын үеийн эмнэлзүй, авах арга хэмжээ цахим сургалтад 45 эмч, эмнэлгийн ажилтныг тус тус хамруулж мэдлэгийг дээшлүүлээ. Сурган дадлагажуулсан мэргэжлийн анги 2		

	1.1.5	Цахим шилжилт, туршилтыг ерөнхий боловсролын 8 сургуульд нэвтрүүлэх	нэвтрүүлсэн сургуулийн тоо	тоо	2021-2024		2023	6	8		
	1.1.6	Багш нарыг зөөврийн компьютерээр бүрэн хангах	зөөврийн компьютерээр хангагдсан багш нарын хувь	хувь	2021-2024		2023	95	100		
	1.1.7	Цахим платформ ашиглан багш сурагчдыг сургалт арга хэмжээнд хамруулах	Арга хэмжээний тоо	тоо	2021-2024		2023	8	10		
			сурагчдын хамралтын хувь	хувь	2021-2024		2023	70	75		
2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО											
Зорилго	2	Хүний хөгжлийн үзүүлэлт 2019 онд 0.689 байсныг 2024 онд 0.719 хувьд хүргэнэ.	Хүний хөгжлийн үзүүлэлт	Индекс	2021-2024			0.711	0.719		
2.1. Эрүүл мэнд											
Зорилго	2.1	Хүн амын дундаж наслалт 2019 онд 74.03 байсныг 2024 онд 75-д хүргэнэ.	Хүн амын дундаж наслалт	тоо	2021-2024	-	2023	74.75	75	Аймгийн хүн амын дундаж наслалт 74.87 байна.	
			эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүү	тоо	2021-2024	-	2023	7.6	7.5	Эрэгтэй дундаж наслалт 71.27, эмэгтэй дундаж наслалт 80.03 байна. Эрэгтэй эмэгтэй хүний дунаж наслалтын зөрүү 8.76 байна.	
Зорилт	2.1.1	Халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлт 2019 онд 57.8 байсныг 2024 он гэхэд 67.4 хувьд хүргэнэ.	Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	хувь	2021-2024	ЭМДСан 640.0	2023	65	67.4	Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэгт артерийн гипертензи, чихрийн шижин хэв шинж -2, хөх, умайн хүзүүний өмөнгийн үзлэгийн хамрагдалт эхний 4 сарын байдлаар 19.2 хувьтай байна.	
Арга хэмжээ	2.1.1.1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг байгуулах	Эрүүл мэндийг дэмжих төвийн тоо	тоо	2021-2024	УТХО 85.0	2023	1	1	2022 онд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт байгуулж 1,152,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр ханган 347,8 сая төгрөгийн засвар үйлчилгээ, 35,626,3 төгрөгийн тавилга, эд хогшлийн хангалт хийж үйлчлүүлэгчид ээлтэй орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Эхний 4 сарын байдлаар 18-аас дээш насны 434 иргэнд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг хийсэн байна. Ходоодны дурангаар ханган 95 иргэнд оношилгоо хийж, 5.2 хувьд өвчлөл илэрүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт илгээлээ.	
	2.1.1.2	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, "Эрүүл мэндээ дээдлэгч иргэн", "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага"-ын тоог нэмэгдүүлэх.	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэний тоо	тоо	2021-2024	УТХО 4.2	2023	44	49	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох хүрээнд танхимын сургалтыг 174 удаа 8898 хүнийг хамруулж, 2895 гарын авлага материалыг тарааж сурталчилсан. Эрүүл мэндийн байгууллагуудын олон нийтийн цахим мэдээллийн хэрэгслээр 136 удаа мэдээлэл, зөвлөмжийг түгээж хандалтаар 28859 хүн үзэж мэдээлэл авсан байна. Үүнээс нийт сургалтад хамрагдсан иргэдийн 3965 буюу 44.5% нь эрэгтэйчүүд байна. Эхний 4 сарын байдлаар нийт хүн амын 18.9%-д эрүүл мэндийн боловсрол олгосон. "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон, иргэн, өрх гэр бүл"-г шалгаруулах болзол, журмыг Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 3 сарын 5-ны өдрийн 01/128 тоот албан бичгээр нийт байгууллага, аж ахуй нэгжүүдэд хүргүүлсэн. Болзол журмын дагуу шалгаруулалтыг 4 дүгээр улиралд зохион байгуулна.	

2.1.1.3	Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах.	Зорилтот бүлгийн иргэдийн үзлэгт хамрагдалтын хувь	хувь	2021-2024	ЭМДСан 640.0	2023	51	54	Аймгийн хэмжээнд 85 халдварт өвчлөл бүртгэгдсэн бөгөөд үүнээс салхинцэцэг 38, сүрьеэ 8, бэлгийн замаар халдварт өвчлөл 28, гар хөл амны өвчин 3, гахай хавдар 2, Елом 1, Бруцеллээ 5 байна. Халдварт өвчлөлийн түвшин 10000 хүн амд 18.2 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 17.5-аар буурсан байна.Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 22795 иргэнээс 4391 буюу 19,3%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 24056 иргэнээс 4459 буюу 18,5%, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2295 иргэн хамрагдахаас 539 буюу 23,5%, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8043 иргэн хамрагдахаас 1270 буюу 15,8%-тай хамрагдсан байна. Зорилтот иргэдийн үзлэгт хамрагдалт 19.2 хувьтай байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитай 20, чихрийн шижинтэй 2 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авч эмчилгээ хийж байна.	44.6
		Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын эзлэх хувь	хувь	2021-2024	УТХО 7.8	2023	33.8	34.0	Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч судын гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 5 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын багийг томилгоожуулан 14 сумдад урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж нийт 2096 иргэн, Улсын Нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтарсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог аймгийн хэмжээнд 6 суманд төвлөрүүлэн 15 хоногийн хугацаанд 18 дээш насны 1083 иргэнийг тус тус хамрууллаа. Нийт 3179 иргэн үзлэгт хамрагдлаа. Эхний 4 сарын байдлаар амбулаторийн тусламж үйлчилгээний 58025 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс 10537 иргэн хамрагдаж 18.2 хувьтай байна.	
2.1.1.4	Өвөр Монголын өөртөө засах орны уламжлалтын эмчилгээ, оношлогооны эмч нарын үзлэгийг орон нутагт зохион байгуулах.	Орон нутагт үзлэг зохион байгуулсан эсэх	Тийм 1, Үгүй 0	2021-2024	-	2023	1	1	2023 оны10 дугаар сарын 23 –ны 01/ 1340 дугаартай аймгийн засаг даргын албан бичгийг Өвөр Монголын өөртөө засах орны Баяннуур аймгийн Ардын засгийн ордонд явуулсан бөгөөд зөвшөөрөл олгогдоогүй гэдэг шалтгаанаар ирээгүй болно. Дахин Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02 –ны өдрийн 01/1385 албан бичгээр 2024 оны төлөвлөгөөнд оруулж хамтран ажиллах хүсэлтээ хүргүүлээд байна Хариу ирээгүй байна.	ХБ
		Үзлэг оношилгоо, эмчилгээ хийлгэсэн иргэдийн тоо	тоо	2021-2024	-	2023	0	3500	хариу ирээгүй	
2.1.1.5	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтыг сумдын ИТХ-аар шийдвэрлүүлэх.	Зайлшгүй болон амин чухал эмийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 5.6	2023	89.5	90	Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн зайлшгүй шаардлагатай болон амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэлд 44 бацгийг Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах хуулийн дагуу тендер зарлан сонгон шалгаруулж худалдан авч хүртээмжийг нэмэгдүүлж байна. Орион фарм эмийн программ ашиглан эмийн чанар, аюулгүй байдлын дотоод хяналт хийгдэж, зайлшгүй шаардлагатай, амин чухал эмийн хангалт 89,6 % тай байна.	99.7
		Төлбөрийг нь төр хариуцдаг эмийн гүйцэтгэлийн хувь	хувь	2021-2024		2023	86	88	Төлбөрийг нь төр хариуцах эмийн батлагдсан төсөв 24,591,800 төгрөг байна. Эхний 4 сарын байдлаар 7 төрлийн оношоор 216 хүнд 5,657428 төгрөгийн төлбөрийг нь төр хариуцах эмээр үйлчилсэн. Эмчийн бичсан жорын дагуу төлбөрийг төр хариуцах эмийг шаардлагатай хүмүүст зохиох журмын дагуу 100 хувь олгож эмчилгээ тусламж авсан.	
		Эрх зүйн орчин шийдвэрлэгдсэн эмийн эргэлтийн сангийн тоо	Тоо	2021-2024	-	2023	0	15	Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг аймгийн ИТХ-ын 16 дугаар хуралдааны 2023 оны 12 сарын 04-ны 49 дүгээр тогтоолоор 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс татан буулгах, хувьчлах шийдвэр гаргасан. Хувьчлах бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захиралмаар баталсан. Мөн Эрүүл мэндийн газраас 5 дугаар сарын 20-ноос эхлэн Эмийн эргэлтийн санд газар дээр заавар зөвлөмж өгөхөөр удирдаж хүргүүлээ.	
	Эхийн эндэгдэлгүй ажиллаж, тав хүртэлх насны	Эхийн эндэгдэлийн түвшин	түвшин	2021-2024		2023	0	0	2024 оны эхний 4 сард нийт 201 эх төрж, амьд төрөлт 200 бүртгэгдсэн. Нийт төрсөн эхчүүдийн 95.0 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтад төрсөн байна. Жирэмсний эрт үеийн хяналт 96.5 байгаа бөгөөд урьд оны мөн үеэс 5.0 хувиар өссөн байна. Эхийн эндэгдэлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.	100

Зорилт	2.1.2	хүүхдийн эндэгдлийн түвшин 2019 онд 10.8 байсныг 2024 онд 9 хүргэж бууруулна.	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/	промилль	2021-2024	УТХО 10.3	2023	10.3	9	Өнгөрсөн оны мөн үед 4.1 промилль байсан бөгөөд эхний 4 сарын байдлаар 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлгүй бүртгэгдээгүй байна.	100
Арга хэмжээ	2.1.2.1	Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах	Эхчүүдийн амрах байраар амарсан эхийн тоо	тоо	2021-2024	УТХО 22.8	2023	285	300	Аймгийн хэмжээнд нийт 199 жирэмсэн эх жирэмсний хяналтад бүртгэгдэж хожуу хяналтад 7 эх орж, жирэмсний эрт хяналт 96.5 хувьтай байна. Эхийн амрах байраар 16 эх амарч, 80 ор хоног ашигласан байна. Амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах төслийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эмч нар боловсруулан сумын Засаг даргын тамгын газарт орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр хүргүүлээ. эхний 4 сарын байдлаар нийт 16 эх амарч, өссөн дүнгээр 301 эх болсон байна.	100
	2.1.2.2	0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх	Чийрэгжүүлэлтэд хамрагдсан хүүхдийн тоо	тоо	2021-2024	УТХО 5.3	2023	4	3	Эхний 4 сарын байдлаар 0-5 насны 4257 хүүхэд жинлэхээс 1938 хүүхэд буюу 45, 5 хувийг жинэлсэн байна. Туранхай хүүхэд 1, тураалтай 1 хүүхэд тус тус бүртгэгдэж хоол тэжээлийн зөвлөгөө өгч багийн эмчийн хяналтад авч гэрээр чийрэгжүүлэлтэд хамруулан сувилагаа эмчилгээ хийлээ. Чийрэгжүүлэлтэд хамрагдаж буй хүүхэд 2	100
Зорилт	2.1.3	Хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2019 онд 91.5 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ.	Хэрэглэгчийн үнэлгээний хувь	хувь	2021-2024	УТХО 332.9 ЭМДС 4.363.3	2023	93.1	93.6	Эхний 4 сарын байдлаар 13.13.тп цахим хаягаар эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдээр үйлчлүүлж буй 960 иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний судалгааг авч дүгнэхэд хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 84.8 хувьтай байна. Нийт эмнэлгүүд OR код уншуулан үнэлгээ авдаг болсон.	90.6
Арга хэмжээ	2.1.3.1	Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи, сумдыг мобайль технологигоор хангах	Тоног төхөөрөмжийн тоо	тоо	2021-2024	УТХО 35.9	2023	1	0	2023 онд Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Компьютер томографыг улсын төсвийн 1 тэрбум 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар авч суурилуулсан. Эхний 4 сарын байдлаар 163 хүнд шинжилгээ оношилгоо хийж, эмнэлзүйн чухал шаардлагатай эмчлүүлэгчид дүгнэлт гаргаж, хугацаа алдалгүй мөс засал болон эмийн эмчилгээг 43 иргэнд хийлээ. Хавдар 17, цус харвалт 15, хугарал 5, бөөрний чулуу 3, уушиг чалчийх 2, уушигны буглаа 1, нурууны сүрьеэ 1 тус тус яаралтай оношлож 3 шатлалд очих урсгалыг буурууллаа.	93.3
			Мобайль технологигоор хангагдсан сумын тоо	тоо	2021-2024	УТХО 15.2	2023	12	15	Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төв нь гүйцэтгэлийн санхүүжилт 15.2 сая төгрөгөөр мобайль технологи авч алслагдсан багийн 33 иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлээ. Ингэснээр өссөн дүнгээр 13 сумын эрүүл мэндийн төвийн мобайль технологиор хангагдлаа.	
	2.1.3.2	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтыг хэрэгжүүлэх.	Нэр төрлийн тоо	тоо	2021-2024	ЭМДС 4.363.3	2023	14	14	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд бүрэн шилжсэн. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээ 18 нэр төрөлөөр сар бүр авч байна. Эхний 4 сарын байдлаар 4.396.0 санхүүжилт авахаас 4.363.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.	100
			Санхүүжилтын гүйцэтгэлийн хувь	хувь	2021-2024		2023	91.5	93	Гүйцэтгэлийн санхүүжилт 99.2 хувь	
	2.1.3.3	Хот хоорондын зам дагуух сумдын болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах.	Яаралтай тусламжийн цэгийн тоо	тоо	2021-2024	УТХО 1.5	2023	5	6	Сайнцагаан сумаар дамжин өнгөрөх Автозамын пост, Хулд, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо сумдад яаралтай тусламжийн 5 цэгийг байгуулан ажиллаж байна. 2024 онд Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн "Яаралтай тусламжийн цэг"-ийг нээхээр төлөвлөж 6 нэр төрлийн 10 тоног төхөөрөмж, Сайхан-Овоо сумын яаралтай тусламжийн цэгт нэмэлтээр тоног төхөөрөмж авахаар тендер шалгаруулалт зарлагдсан. Яаралтай тусламжийн цэгтэй болсноор зам тээврийн осол 11, бусдад зодуулсан 5, уналт 10, осолт 1, түлэгдэлт 1, нохойд уруулсан 2 тохиолдлуудад эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг 100 хувь үзүүлсэн.	100
	2.1.3.4	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног,	Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 44.9	2023	47	48	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн болон гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор 6 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Яаралтай тоног төхөөрөмжийн хангалт 79.5 хувьтай байна.	100
			Тоноглогсон тоо	тоо	2021-2024	УТХО 40.0	2023	4	5.0	Улсын төсвийн 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын Эрүүл мэндийн төвд ЛАНД 78 маркын автомашиныг бүрэн тоноглогсон. Тоноглогсон автомашин 1 өссөн өссөн дүнгээр 5 боллоо.	

		төхөөрөмжөөр тоноглох	Машины хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 184.0	2023	94	95	Улсын төсвийн 184.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын Эрүүл мэндийн төвд ЛАНД 78 маркын автомашин, Говьугтаал сумын эрүүл мэндийн төвд Pгоbox маркийн автомашиныг тус тус хүлээлгэн өгч, яаралтай түргэн тусламжийн бэлэн байдлыг хангалаа. Автомашин хангалт 98.0 хувьтай байна.	
	2.1.3.5	Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютерээр хангах.	2 дагч шатлалын эмнэлгээс онлайнаар зөвлөгөө авсан тоо	тоо	2021-2024	УТХО 2.1	2023	25	30	Эхний 4 сарын байдлаар төрөлжсөн нарийн мэргэжлийн төвөөс зөвлөгөө 5 удаа, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар 6 удаа зөвлөгөөг тус тус өгсөн. Мөн цахимаар гэмтлийн үеийн тусламж үйлчилгээ, эмийн чанар аюулгүй байдал, олон улсын эмнэлзүйн программ хэрхэн ашиглах, хүүхэд болон насанд хүрэгчдийн томуугийн эмчилгээ, гамшгийн үеийн сэтгэлзүйн тусламж зэрэг нийт 6 удаагийн зөвлөгөө мэдээлэл хүргэлээ. 2 догч шатлалын эмнэлгээс нийт 11 удаа зөвлөгөө авч эмчилгээ, оношилгоо 100 үр дүнгээ өгсөн.	100
			Компьютерийн тоо	тоо	2021-2024	УТХО 9.3	2023	49	50	Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, Адаацаг, Дэрэн, Хулд сумын эрүүл мэндийн төвүүд нь гүйцэтгэлийн санхүүжилтээр 4 компьютер авч эрүүл мэндийн салбарын албан хаагч нарын албан хэрэгцээнд зориулан цахимаар эмчилгээ үйлчилгээ, оношилгоо авах боломжийг бүрдүүлээ. Шинээр авсан компьютер 4 өссөн дүнгээр 53 болсон.	
Дэд зорилт	2.1.3.1	Эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ.	Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 222.0 Хандив 514.4 ОНХС 299.0	2023	86.0	86.7	Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 19 нэр төрлийн 507.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 92.1 хувьтай байна.	100
	2.1.3.1.1	Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих.	Тухайн жилд шинээр барьсан эмнэлгийн барилгын тоо	тоо	2021-2024	-	2023	0	3	2024 оны улсын төсөвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн барилга, 20 сая төгрөгийн 100 ортой амгийн Нэгдсэн эмнэлгийн гадна талбайн засварын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажил хангагдсан. 2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой шинэ барилга ашиглалтад орж үйл ажиллагаа нь жигдэрсэн. Өндөршил, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг хойшлогдсон.	ХБ
	2.1.3.1.2	Нэгдсэн эмнэлгийн амбулатори, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилгуудад их засвар, Боржигон мандал, Өлзийт мандал, Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвд өргөтгөл хийх.	Засвар хийгдсэн эмнэлгийн тоо	тоо	2021-2024	УТХО 28.9 Хандив 200.0	2023	6	6	Орон нутгийн хөгжлийн сангийн 185.0 сая төгрөгөөр Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилгын засвар, Адаацаг, Луус сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засвар хийгдэхээр бэлтгэж ажил хангагдсан. Дэлгэрцогт сумын эрүүл мэндийн төв нь М-Си-Эс группын хандив тусламж 200.0 сая төгрөгөөр засвар хийж, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлийн санхүүжилт 17.0 сая төгрөгөөр статистик, нягтлан бодогч, яаралтай тусламж, эмчийн өрөө зэрэг нийт 11 өрөөний хаалгыг сольж, Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төв гүйцэтгэлийн санхүүжилт 11.9 сая төгрөгөөр тус тус засвар хийлээ. Засвар хийсэн эмнэлгийн тоо 1 болж өссөн дүнгээр 6 болсон.	50
			Өргөтгөл нийсэн эмнэлгийн тоо	тоо	2021-2024	ОНХС 299.0	2023	1	1	Боржгонмандал өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг 2025 онд барихаар хойшлогдсон. Өрхийн эрүүл мэндийн төвийг цэвэр, бохир ус, нийтийн халаалтад холбохоор зураг төслийн ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 299.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.	
Арга хэмжээ		Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн	Сум өрхийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 24.5 Хандив 74.5	2023	79.0	80.0	Баянжаргалан, Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвүүд гүйцэтгэлийн санхүүжилтээр 15.5 сая төгрөгөөр ариутгалын ам наагч, 13 камер, гаднах гэрлэн хаяг, проектор зэрэг 8 төрлийн тоног төхөөрөмж, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлийн санхүүжилтээр 9.0 сая төгрөгөөр 12 орыг тус тус худалдан авчорчин нөхцөлөө сайжрууллаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зулын нөхцөл байдалтай холбогдуулан Өлзийт, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдад нийт 13.0 сая төгрөгийн бүлээцүүлэх хөнгөл, 7,8 сая төгрөгийн хэм хяналтын термостат, аймгийн хэмжээний нийт 68 багийн эмч нарын ажиллах нөхцлийг сайжруулах хүрээнд 53.6 сая төгрөгийн багийн эмчийн үзлэгийн цүнхийг тус тус хандивлан өглөө. Сум өрхийн тоног төхөөрөмжийн хангалт 89.1 хувьтай байна.	100

	2.1.3.1.3	эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангах.	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 168.1 Хандив 239.9	2023	93.0	93.5	Аймгийн нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт, Зурх судасны төслийн хүрээнд 137.6 сая төгрөгийн V7N маркын зүрхний ЭХО аппарат, 30.5 сая төгрөгийн өртөгтэй ходоодны уян дуран, НҮБ-ын Хүүхдийн амын сангийн 239.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар STERIPPLUS-40 маркийн хог хаягдлын автоклавыг тус тус нийлүүлээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Зооноос өвчин судлалын төвийн лабораторийн чадавхийг сайжруулах зорилгоор PCR –ын шинжилгээний аппарат, дагдалдах хэрэгслэл, био аюулгүй кабинет, лабораторийн ширээ, хөргөгч, хөлдөөгч зэрэг нийт 8 төрлийн тоног төхөөрөмжийг олголоо. Ингэснээр аймгийн Нэгдсэн эмнэлгээс гадна орон нутагт шаардлагатай PCR-ийн шинжилгээг нэмэлтээр хийдэг болсон. Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 95.2 хувьтай байна. [2]	100
	2.1.3.1.4	Нүхэн жорлонтой эрүүл мэндийн байгууллагуудын дунд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох хөдөлгөөнийг үе шаттай өрнүүлэх.	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай ЭМБ-ын эзлэх хувь	хувь	2021-2024	УТХО 0.5	2023	84.2	85	"Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай айл, өрх, эрүүл мэндийн төв шалгаруулах" болзолт уралдааны удирдамжийг зарлаж эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлээ. 11 дүгээр сард болох "Дэлхийн 00" өдрөөр шалгуурлалт хийгдэнэ. Аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Стандарт хэмжээний хэлтэс, Монголын жорлонгийн ууган холбоо болох "ГҮТББ" -ТББ-тай хамтран нүхэн жорлонгийн өнөөгийн нөхцөл байдал, сөрөг үр дагавар, байгальд ээлтэй эко жорлон, ариун цэврийн байгууламжийн талаарх мэдээллийг иргэдэд олгох, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх зорилгоор "ЭХО ЖОРЛОН" сургалт, үзэсгэлэн нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа. Сургалтад 120 хүн оролцож, 6 төрлийн гарын авлагыг 330 иргэнд тарааж мэдлэг олгосон. Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдээс 4 эрүүл мэндийн байгууллага шаардлага хангахгүй ариун байгууламжтай байгаа бөгөөд сайжруулах ажлын зураг төсвийн хамт Эрүүл мэндийн яаманд хүргүүлээд байна. Нийт анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 86,6 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон.	100
Зорилт	2.1.4	Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 96.7 хувь байсныг 2024 он гэхэд 97.5 хувьд хүргэнэ.	Хүний нөөцийн хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 78.8	2023	97.0	97.5	Эрүүл мэндийн салбарт 758 эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажиллахаас 692 ажиллаж хүний нөөцийн хангалт 91.2 хувьтай байна.	93.6
Арга хэмжээ	2.1.4.1	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх замаар орон сууцаар хангах	Орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь	хувь	2021-2024	УТХО 36.0	2023	43	45	Эрүүл мэндийн салбарын нийт албан хаагчдын 43,3 хувь нь гэр болон түрээсийн байранд амьдарч байна. Хулд сумын эрүүл мэндийн төвд шинээр ирсэн 1 эмчийг албаны байранд оруулж, тогтвортой ажиллаж амьдрах таатай нөхцөлийг нь бүрдүүлсэн. Орон сууцаар хангагдсан албан хаагчийн эзлэх хувь 56.7	100
	2.1.4.2	Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэх.	Нарийн мэргэжлийн эмчийн хангалтын хувь мэргэшүүлсэн эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо	хувь тоо	2021-2024 2021-2024	УТХО 12.5 УТХО 20.0	2023 2023	95 33	96.9 43	Нэгдсэн эмнэлэгт хавдрын хими эмчилгээ, нярай, компьютер томографикаар, эмнэл зүйн эм зүй, эх барих, эмгэгтэйчүүдийн хэт авиан оношилгоо, хавдрын хими эмчилгээ чиглэлээр 6 эмчийг мэргэшүүлэх сургалтад тус тус хамруулж байна. Нарийн мэргэжлийн эмчийн хангалт 97.0 хувьд хүрсэн. Гурвансайхан, Дэрэн, Нэгдсэн эмнэлгүүдэд дархлаажуулалт, хүүхэд, Компьютер томограф-рентген туяа, Гэр бүл төлөвлөлтийн эх барих, яаралтай тусламж чиглэлээр мэргэшүүлэн бэлтгэж, Говьутгаал, Эрдэнэдалай сумдын эрүүл мэндийн төвүүдэд бүртгэл мэдээллийн ажилтан, мэс заслын сувилагчийн дээшлүүлэх сургалтад хамрууллаа. эхний 4 сарын байдлаар нийт 8 сувилагч тусгай мэргэжилтэнг бэлтгэгдэж өссөн дүнгээр 41 болов.	97.6
дэд арга	2.1.4.2.1	Анагаахын их сургуулиудтай хамтран ажиллаж орон нутагт нэн шаардлагатай сувилагч мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх.	Сувилагч мэргэжилтний хангалтын хувь	хувь	2021-2024	УТХО 2.3	2023	86.7	87.0	Анагаахын сургуультай хамтран ажиллах хүрээнд Эрүүл мэндийн газар, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төвийн удирдлагууд АШУҮИС-ийн харьяа Дорноговь аймаг дахь салбар сургуулийн төгсөх курсын оюутнууд болон, одоо суралцаж буй орон нутгийн нийт 19 оюутантай уулзаж, цаашид салбарын хүний нөөцийг бэлтгэх, дутагдалтай байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нөхөх, элсэлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сургалтын чиглэлээр хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгууллаа. Уулзалт зохион байгуулснаар 2024 оны 6 сарын төгсөлтөөр нийт 4 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг аймагт ажиллуулах асуудлыг шийдвэрлэж, сувилагчийн хангалт 87.2 хувьд хүрсэн.	100

ХЭМЖЭЭ	2.1.4.2.2	"Ахмадын ордон", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв"-д ахмад настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшлийн хүний нөөцийг сурган бэлтгэх.	Сэргээн засах тусламж үзүүлэх мэргэшсэн хүний нөөцийн тоо	тоо	2021-2024	-	2023	2	4	2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв шинээр ашиглалт орж, 4 их эмч, 2 сэргээн засалч, техникч 1-ыг мэргэшүүлэн сургаж ажиллуулж байна. Ахмадын ордонд аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахмадын эмч давхар хариуцан ажиллаж байна. Бэлтгэсэн мэргэжилтний тоо 7.	100
Арга хэмжээ	2.1.4.3	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн нарийн мэргэжлийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг туршлага судлуулж, сургалтад хамруулах.	Гадаад сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	тоо	2021-2024	УТХО 8.0	2023	69	79	Эрүүл мэндийн газрын дарга Бүгд Найрамдах Солонгос, Япон улсад, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргыг Бүгд Найрамдах Солонгос улсад удирдлагын чиглэлээр, Индонез, Хөх хотод болсон олон улсын бага хуралд аймгийн Нэгдсэн эмнэлгийн нүдний эмчийг, аймгийн Нэгдсэн эмнэлийн дотрын эмчийг Банконг улсад тус тус сургалтад хамрууллаа. 2024 оны эхний 4 сарын байдлаар гадаад сургалтад нийт 6 эрүүл мэндийн албан хаагч хамрагдаж өссөн дүнгээр 75 болсон.	94.9

Хэрэгжилт 88.5

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭЖ ГАРГАСАН: ЭМГ-ЫН ХШУДА ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

П.ОЮУНЧИМЭГ

Б.АЛТАНТӨГС